

**Гадаад худалдааны өнөөгийн
байдал, худалдааны
зохицуулалтыг боловсронгуй
болгох зарим асуудал**

**Монголын Экспортлогчдын Холбооны тэргүүн
Д.Галсандорж**

АГУУЛГА

- * Нэг. Гадаад худалдааны өнөөгийн байдал
- * Хоёр. Гадаад худалдаанд тулгамдсан зарим асуудал
- * Гурав. Худалдааны зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ

Нэг. Гадаад худалдааны өнөөгийн байдал

Хүснэгт№1: Гадаад худалдааны алдагдал

Үзүүлэлт	2012.08 (сая ам.дол)	2013.08 (сая ам.дол)	Харьцуулалт хувиар (2013/2012)	
НИЙТ БАРАА ЭРГЭЛТ	7531,1	6960,1	92,4	↓
ЭКСПОРТ	2871,6	2703,2	94,1	↓
Валютын төлбөртэй бараа	2866,7	2699,4	94,2	↓
Боловсруулсан бараа	3,1	3,4	108,1	↑
Тусламжийн бараа	0,2	0,0	0	
Бусад	1,6	0,4	28,7	↓
ИМПОРТ	4659,5	4256,5	91,4	↓
Валютын төлбөртэй бараа	4006,7	3923,4	97,6	↓
Бараа солилцоо	0,02	0,05	201,0	↑
Тусламжийн бараа	95,7	60,1	62,8	↓
Хөрөнгө оруулалтаар хийсэн бараа	584,9	260,7	47,5	↓
Гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа	5,6	7,5	134,3	↑
Боловсруулсан бараа	0,9	1,0	105,1	↑
Бусад	1,7	4,1	243,7	↑
ТЭНЦЭЛ	-1787,9	-1553,3		

Хүснэгт№2: Импортын шинжилгээ

Үзүүлэлт	2012.08	2013.08
Нийт бараа эргэлт, сая ам.доллар	7531,1	6960,1
Валютын төлбөртэй импортын барааны нийт импортод эзлэх хувь	86,0	92,2 
Хөрөнгө оруулалтын барааны нийт импортод эзлэх хувь	12,6	6,1 
Зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн барааны нийт импортод эзлэх хувь	0,1	0,2 

Хүснэгт№3: Экспорт, импортын барааны гүйцэтгэл, (сая ам.доллар)

№	Барааны төрөл	Экспорт, эхний 8 сард		Импорт, эхний 8 сард		Экспортын харьцуулалт хувиар (2013/2012)	Импортын харьцуулалт, хувиар (2013/2012)
		2012	2013	2012	2013		
1	Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	2556,0	2165,5	1068,9	1060,0	84,7 ↓	99,2 ↓
2	Бусад бүтээгдэхүүн	315,6	537,7	3590,6	3196,5	170,4 ↑	89,0 ↓
3	Нийт экспорт, импортын дүн	2871,6	2703,2	4659,5	4256,5	94,1 ↓	91,4 ↓
4	Эрдсийн бүтээгдэхүүний эзлэх хувь -%	89,0	80,1	22,9	24,9	-8,9 ↓	+2,0 ↑
5	Бусад бүтээгдэхүүний эклэх хувь-%	11,0	19,9	87,1	85,1	+8,9 ↑	-2,0 ↓

Хүснэгт №4: Экспортын барааны гүйцэтгэл, гол нэрийн бараагаар (сая ам.доллар)

№	Бүтээгдэхүүний нэр	2012		2013		Өөрчлөлт (+/-)				
		Экспорт, эхний 8 сард						2013.08/2012.08		
		Тоо хэмжээ	Үнийн дүн (Сая.дол)	Тоо хэмжээ	Үнийн дүн (Сая.дол)	Тоо хэмжээ	Үнийн дүн (Сая.дол)	Нийт экспортод эзлэх хувь		
Эрдсийн бүтээгдэхүүн			2556,0		2165,5		-390,5			
1	Нүүрс (сая.тн)	12,1	1246,9	9,6	693,0	-2,5	-553,9	25,6		
2	Зэсийн баяжмал (мян.тн)	381,5	557,6	395,5	562,8	+14,0	5,2	20,8		
3	Төмрийн хүдэр, баяжмал (сая.тн)	4,3	356,4	4,3	442,2	0,0	+85,8	16,4		
4	Боловсруулаагүй нефть (мян. баррель)	2146,4	206,7	3052,3	297,7	+905,9	+91,0	11,0		
5	Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, (мян.тн)	1,4	60,8	4,7	195,2	+3,3	+134,4	7,2		
6	Цайрын баяжмал (мян.тн)	77,4	73,0	86,0	80,4	+8,6	+7,4	3,0		
7	Жоншны баяжмал (мян.тн)	282,1	65,6	221,3	56,3	-60,8	-9,3	2,1		
8	Молибдены баяжмал(мян.тн)	2,8	26,4	2,7	20,8	-0,1	-5,6	0,8		

Хүснэгт№5: Импортын барааны гүйцэтгэл, гол нэрийн бараагаар (сая ам.доллар)

Бүтээгдэхүүний нэр		2012	2013	Өөрчлөлт	Импортод эзлэх хувь
		Эхний 8 сар			
Эрдсийн бүтээгдэхүүн		1068,9	1060,0	-8.9	24.9
1	Нефтийн бүтээгдэхүүн		853,3		20.0
2	бусад		206.7		4.9
Бусад төрлийн бүтээгдэхүүн		315,6	537,7	+222,1	85.1
1	Машин, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл	1158,4	955,3	-203,0	22,4
2	Авто, агаарын болон усан замын тээврийн хэрэгсэл	959,5	820,1	-139,4	19,3
3	Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн.	408,3	368,8	-39,5	8,7
4	Хүнсний бүтээгдэхүүн болон аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа. Үүнээс:	319,8	328,8	+9,0	7,8
	- сүү	13.5	10,7	-2.8	
	- хүнсний ногоо	8.3	5.7	-2,6	
	- архи, пиво	18,8	22.0	+1,2	
5	Химийн болон түүнтэй холбоотой бүтээгдэхүүн	192,0	199,1	+7,1	4,7
6	Хуванцар болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	161,9	155,2	-6,7	3,6
7	Цемент	63.3	70.1	+6.8	1.6
бусад					8.6

Хоёр. Гадаад худалдаанд тулгамдсан зарим асуудал

Гадаад худалдаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж чадахгүй ихээхэн алдагдалтай байсаар байна. Үүний шалтгаан тулгамдсан асуудлыг дурдвал:

1. Экспортын бүтээгдэхүүний нэр төрөл цөөн, угаасан нүүрс, зэс, алт, ноос, ноолуур, арьс ширийг эс тооцвол ихэвчлэн түүхий эд хэлбэрээр экспортлож байна.
2. Экспортын шинэ төрлийн бүтээгдэхүүн, ялангуяа нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэхгүй байна.
 - Гадаадын зээлийн хөрөнгийг үйлдвэрлэл, ялангуяа экспортын чиглэлийн үйлдвэрлэлд маш бага хуваарилж байна.
 - Гадаадын зах зээлд босгосон бонд болон дотоодын бондын хөрөнгийг арьс ширний үйлдвэрүүдийн техник, технологийг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, уул уурхайн одоо ажиллаж байгаа болон шинэ төслүүдэд хуваарилан ашиглах шаардлагатай байна.
 - Эцсийн бүтээгдэхүүн экспортлогчдод татварын хөнгөлөлт, төслийн санхүүжилтийг олгохгүй байна.
 - Уул уурхайн бүтээгдэхүүнд ноогдуулж байгаа өсөн нэмэгдсэн нөөц ашигласны төлбөр нь оновчтой бус байна.

3. Импортыг орлох, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих импортын зохистой бодлого авч хэрэгжүүлэхгүй байна.
 - Импортоор 440 сая ам.доллар төмөрлөг, арматурын төмөр, 70 сая ам.долларын цемент авч байна.
 - 18.8 сая ам.долларын архи пиво, 5.7 сая ам.долларын төмс хүнсний ногоо
 - Нефть боловсруулах үйлдвэр барьж байгуулах асуудал удаашралтай байна.
4. Экспорт, импортын худалдааг хөнгөвчлөх асуудлыг эрчимжүүлэх, дэд бүтцийг байгуулах:
 - Зөвшөөрөл, лицензийг тоог багасгах, оновчтой болгох
 - Гааль, мэргэжлийн байгууллагуудын хяналтыг хурдан шуурхай болгох
 - Хилийн боомтын дамжин өнгөрөх чадварыг нэмэгдүүлэх

Гурав. Худалдааны зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ

Гадаад худалдааны алдагдлыг багасгах экспорт, импортыг зохистой болгохтой холбогдуулан дараах арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Үүнд:

1. Гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох

- Хэд хэдэн засгийн газар дамжин гарахгүй байгаа “Гадаад худалдааны зохицуулалтын хууль”-ийг эцэслэн боловсруулж батлан гаргах;
- “МУ”-ын худалдааны салбарт дунд хугацаанд баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах;
- Төсөл нь бэлэн байгаа худалдааны хамгаалалтын арга хэмжээний хууль
- Экспортын санхүүжилт, даатгалыг цогц арга хэмжээ авахад чиглэсэн экспортыг дэмжих хөтөлбөрийг 2013 онд багтаан батлан хэрэгжүүлэх;
- ОХУ, Хятад улстай тарифын ба тарифын бус хязгаарлалт, хориг саадыг багасгахад чиглэсэн хэлэлцээ ЗГ-уудын түвшинд хийх;
- Чөлөөт бүсүүд, АҮП-уудыг ажиллуулах (Замын-Үүд)
- Сайншандын АҮП бүтээн байгуулалтыг эхлүүлэх

2. Гадаад худалдааны бодлогын гол хэрэгсэл болсон гааль, тарифын механизмын экспортыг дэмжих, импортыг зохистой болгоход чиглүүлэх, оновчтой болгох шаардлагатай

- * Гаалийн тарифын нэмэлт, өөрчлөлт оруулах асуудалд худалдааны асуудал хариуцсан яам (ЭЗЯ)-ны оролцоо бага байна.
- * Экспорт, импортын тарифын өөрчлөлтийн асуудлыг (Гаалийн тарифын зөвлөл)-ийг Сангийн яам, Гаалийн Ерөнхий газар хариуцаж нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төсвийн орлогыг бүрдүүлэх, нэмэгдүүлэхэд чиглүүлж байна.
- * Уул уурхайн бүтээгдэхүүний НӨАТ-тогтоож байгаа “Жишиг үнэ” тогтоох аргачлал, үнэ бүрдэх системийг боловсронгуй болгох. Экспортлогчид НӨАТ-ын өрөнд орж байна.
- * Экспорт, импортын тарифыг зохистой болгох, экспортыг татвартай болгох, зарим бараанд импортын татварыг нэмэгдүүлэх

3. Гадаад худалдааны удирдлагын бүтцийг бий болгох

- * Асуудлыг хариуцсан нэгж ЭЗХЯ-нд байхгүй байна.

Газар болгох эсвэл бие даасан Агентлаг байгуулах “Нэг цонхны бодлого”

- * Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бирж
- * Уул уурхайн бүтээгдэхүүний бирж
- * Ил тод арилжаа, зах зээл, өрсөлдөөний зарчмаар үнэ тогтоох, стратегийн худалдан авагчийг татан оролцуулах.
- * Шудрага татвар ноогдуулалт

4. Гуравдагч зах зээлд нэвтрэх, хөрш орнуудад экспортыг нэмэгдүүлэх боломж

- * Японтой чөлөөт худалдааны хэлэлцээ байгуулах бэлтгэл хангах
- * Хятад, ОХУ-тай худалдааг өргөжүүлэх хэлэлцээ, тохиролцоог ЗГ-ын хэмжээнд хийх
- * Экспортын дэд бүтэц, хилийн боомтын асуудлаар тохиролцоо хийх зэрэг болно.



АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА